



Ражив Гандийн нэрэмжит

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллеж

Урлал дизайны тэнхим

# СУРАГЧДЫН СУРАХ ЭРМЭЛЗЛЭЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ЗАМЫГ ЭРЭЛХИЙЛЭХ НЬ

ИЛТГЭГЧ БАГШ: А.ДЭЛГЭРМӨРӨН

Улаанбаатар хот  
2018 он

## **АГУУЛГА**

Нэг. Оршил.....	3
Хоёр. Үндсэн хэсэг.....	4
Гурав: Судалгааны ач холбогдол.....	7
Дөрөв. Судалгааны дүн.....	7
Тав. Дүгнэлт.....	10
Зургаа: Цаашид хэрэгжүүлж болохуйц санаа.....	11
Долоо. Ном зүй:.....	12

## СУРАГЧДЫН СУРАХ ЭРМЭЛЗЛЭЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ЗАМЫГ ЭРЭЛХИЙЛЭХ НЬ

### Нэг. Оршил

Сургууль, багш нарын ажлын гол зорилго нь ирээдүйн эрүүл чийрэг, боловсролтой, хариуцлагатай иргэн төлөвшүүлэх явдал юм. Сүүлийн жилүүдэд хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн асуудал эцэг эх болон багш нарын сэтгэлийг зовоосон асуудал болоод байна. Энэ хүүхдүүд мөн томчууд яагаад нийгэмд ёс бус үйлдэл гаргаад, гэмт хэрэгт олноороо өртөөд байна вэ?

Энд улс орны хөгжил, нийгэм эдийн засгийн байдал, сургалтын тогтолцоо, сургалтын чанар, хүртээмж, гэр бүлийн байдал, эцэг эхийн хөдөлмөр эрхлэлт гээд маш олон зүйлүүдийн нөлөөлөл байгаа нь судалгааны дүнгүүдээс тодорхой харагддаг. Манай сургуулийн онцлог нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэдэг. Мэргэжил бүрээрээ ажил олгогч нартай уулзаж, тэдний хэрэгцээ шаардлагуудыг асууж ярилцаж байхад хүмүүжил, төлөвшил сайтай төгсөгчдийг бэлтгээд өгөөч, суурь хүмүүжил сайтай хүүхдэд ажил заагаад сургаад авч болно гэсэн үгийг удаа дараа сонсч байсан. Эндээс харахад хүүхдийн хүмүүжил, төлөвшил хөдөлмөрийн зах зээл дээр гарахад ямар чухал нь харагдаж байна. Энэ талаар маш олон судалгаа, шинжилгээний ажлууд хийгдсэн байдаг. 2017 онд Ш.Ичинхорлоо багшийн хүмүүжил, түүний талаар хийсэн судалгаа, бодлого илтгэлд хүүхдийн хүмүүжилд нөлөөлж буй хүчин зүйлсүүд нь дараах байдлаар судлагджээ.



## **Хоёр. Үндсэн хэсэг**

1. Юуны өмнө хүмүүжил, төлөвшил, боловсрол гэдэг ойлголтуудыг жаахан тодруулъя.

### ***Доктор профессор Ш.Ичинхорлоо.***

#### **Хүмүүжил.**

Хүмүүжил гэсэн үг нь эртний монгол “хүмүүн” хэмээх үгнээс гаралтай гэж судлаачид үздэг. “Хүмүүжил бол хүүхэд ёс суртахууны, харилцааны, биеэ авч явах, сурч хөдөлмөрлөх олон төрлийн хэм хэмжээг өөрийн эрхэм зан чанар болгох үйл явц”. Бага насны хүүхдийн олж авах зан суртахуун, нийгмийн амьдралд биеэ авч явах чадвар дадал төлөвшсөн зан чанар гэж тайлбарлах нь ч бий. Бид хүмүүжлийг ёс суртахууны, хөдөлмөрийн, бие бялдрын, экологийн, эдийн засгийн, бэлгийн хүмүүжил гэх мэт хэлбэрээр авч үзэж ирсэн. Балчир бага насанд хүний хүмүүжил төлөвшлийн суурь тавигддаг тул бидний анхаарах чухал асуудал нь хүүхэд, өсвөр үеийнхэндээ бие хүний ямар эрхэм чанаруудыг төлөвшүүлэх вэ гэдэгт оршино. Мөн хүүхдийн хүмүүжил 0-6 насанд эрчимтэй явагдаж 10-12 нас гэхэд хүмүүжлийн суурь тавигдаж дуусдаг. Бид “өсвөр насны хүүхдийн хүмүүжил” гэж ярихгүй үүний оронд “өсвөр насны хүүхдийн өөрийн хүмүүжил” “төлөвшил”, “нийгэмшил” гэх үгийг хэрэглэнэ.

#### **Төлөвшил.**

Судлаачид “төлөвшил” бол хүмүүжлийн залгамж холбоо, түүний үргэлжлэл бөгөөд өсвөр, залуу настай илүү холбон тайлбарлах хандлага бий. Зарим судлаач төлөвшлийг урт удаан хугацаанд үргэлжлэх үйл явц гэж үздэг бөгөөд түүний үргэлжлэх хугацаа үндсэндээ тодорхойгүй. “Төлөвшил нь хүн хөгжих үйл явцын үр дүн бөгөөд ... урт удаан хугацааны туршид явагддаг. Энэ нь хүний хөгжилд чанарын өөрчлөлт бий болж тэр нь тогтворжин хүнд тогтонги чанар болон шингэхийг хэлнэ” гэжээ. Ер нь төлөвшил хэмээх үгийн утга нь монгол хэлэнд төлөв томоо суух, байр суурьтай тохитой болох гэж тайлбарлагддаг. Бидний өвөг дээдэс эртнээс төлөвшсөн хүний тухайд төлөв түвшин хүн, буурь суусан хүн, ноён нуруутай хүн, тогтуун томоотой хүн гэх мэтээр сургамжилж ирсэн.

Нийгэмшил.

Хүүхдийн хүмүүжил төлөвшлийн тухай ярихад нийгэмшлийн асуудал зайлшгүй хөндөгддөг. Судлаач Брим (1969) “Нийгэмшил бол хувь хүн нийгмийн болон бүлгийн амьдралд их, бага ямар нэгэн хэмжээгээр үр өгөөжтэй оролцоход хэрэг болох мэдлэг, чадвар, байр суурь, хандлага эзэмших үйл явц” гэж үзсэн. Хүний нийгэмшил хэлд орох үеэс эхэлж насан турш явагддаг ба насны үе болгонд өөр өөрийн онцлогтой. Ингээд дээр өгүүлснээс үзвэл нийгэмшил хүний насан турш үргэлжлэх процесс бөгөөд түүний эхний чухал үе шат бол хүмүүжил юм гэжээ.

***“Голомт” банкны гүйцэтгэх захирал Ө.Ганзориг:***

Үгнээс илүү агуулга нь чухал. Зарим хүн арван жилийн сургууль төгссөнөө, их сургуульд сураад диплом авснаа, математикийн олимпиадад түрүүлснээ боловсрол гэж бодоод байдаг. Би боловсролыг мэдлэгээс салгаж тодорхойлохыг хүсдэг. Мэдлэг, чадвар гэдэг зүйл боловсролоос ялгаатай. Боловсролтой хүн гэдэг нь төлөвшсөн, сэтгэлзүйгээ удирдаж чаддаг, бусаддаа энэрэнгүй, нийгэмдээ хувь нэмэр оруулдаг хүнийг хэлнэ. Манай боловсролын систем ялзарснаас болоод сэтгэлзүйн төлөвшилгүй олон хүнийг бэлтгэж гаргаж байна.

Сэтгэлзүйн төлөвшилгүй хүн бол боловсролгүй хүн. Гэтэл тийм хүмүүс математикийн олимпиадын аварга байж болно шүү дээ. Жимс бүрэн боловсорсон хойноо амттай байдаг. Гэвч бид жимсээр бол түүхий, ногооноороо байгаа жимсийг л амтлаад байна. Боловсролыг би философи ба психологийн төлөвшил гэсэн хоёр талд хувааж авч үздэг. Философийн төлөвшил гэдэгт тухайн хүний амьдралыг харах өнцөг, зорилго, нийгмийн үүргээ ухамсарласан эсэх, амьдралынхаа утга учрыг мэдэрсэн байдал, итгэл үнэмшлийн тухай асуудлыг ойлгож болно. Психологийн төлөвшил гэдэг нь хүн өөрийн эмоци удирдах чадвар буюу уурлах, баярлахаа зөв зохицуулан сэтгэлзүйгээ бүрэн удирдаж чаддаг чадварыг хэлнэ. Эдгээр хоёр зүйл бол боловсролын үндсэн баганууд юм.

***МУИС-ийн Хэрэглээний математикийн тэнхимийн багш Г.Анхбаяр:***

Дөнгөж эзэмшсэн мэдлэг, мэргэжил хоёр жилийн дараа огт хэрэггүй болдог нийгэмд бид амьдарч байна. Тэгэхээр боловсрол гэдэг нь хэрэгцээтэй мэдлэг,

ур чадварыг богино хугацаанд эзэмших чадвар бөгөөд энэхүү чадварыг хүмүүст хэрхэн хүртээмжтэй, өгөөжтэй олгох шинэ арга, технологийн асуудал бас давхар үүссэн. Монголын нийгэм нэг талдаа аархал, омогшил, тэнгэризм ярьсан хэсэг, нөгөө талдаа хөгжих ёстой, боловсрох ёстой, юманд авах гээхийн ухаанаар хандах ёстой гэдэг хэсэг гээд хоёр хуваагдаад байна. Тэгэхээр энэ их мэдээлэл дунд зөв, бурууг ялгадаг чадварыг боловсрол гэх болов уу!

***“Шинэ Монгол” сургуулийн захирал, доктор П.Наранбаяр:***

Миний хувьд боловсрол гэдэг нь зүрх сэтгэл, оюун ухаан, бие бялдарын өв тэгш хүмүүжил олгох процесс. Өөрөөр хэлбэл зөв хүн болгож хүмүүжүүлэх үйл ажиллагаа гэсэн үг гэжээ.

Дээрх хүмүүсийн хүмүүжил, төлөвшил, боловсролын талаар томъёолж хэлсэн үгнүүдээс харахад суралцах идэвхи, хандлага, эрмэлзлэл маш чухал гэдэг нь харагдаж байна.

**2. Өсвөр насны хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогийг судлаж үзвэл:**

- a. Танин мэдэхүйн процессын хөгжилт . хүртэхүйн хөгжилт: Өсвөр насны хүүхэд бодит байдлаас хүртэж байгаа юм үзэгдлийг үлэмж нарийн задлан шинжилж, нэгтгэн дүгнэх чадвартай байна. Амьдралын туршлагаас үзэхэд өсвөр насны хүүхдийн хүртэхүй нь нэг талаас юмыг үлэмж нарийн тусгаж хүртэх, нөгөө талаас үзэгдэл юмсыг өнгөцхөн мөчид тусгах онцлогтой байдаг нь ажиглагдсан байна. Өсвөр насны үед хүртэхүй нь ямагт юм үзэгдлийг өрөөсгөл нэг талаас нь тусган авдаг онцлогтой учраас тэдний хүртэхүйд эндэгдэл гарч гаж буруу тусгал явагдаж болно. Тэрчлэн өсвөр насны хүүхдийн хүртэхүйн нөгөө нэг онцлог нь юмыг хамгийн ерөнхий байдлаар тусгадаг оршино. Ийм учраас өсвөр насны хүүхдийн хүртэхүйн онцлог бол юмыг бодит байдал, биет зүйл дээр тулгуурлан тусгах өвөрмөц шинжтэй байдаг явдал юм. Өсвөр насны хүүхдийн ажиглалтын үр дүн нь хүүхэд өөрөө ажиглалтанд хэрхэн яаж хандахаас шалтгаална.
- b. Өсвөр насны хүүхдийн хийх хөдөлмөрийн сэтгэлзүйн үндэс . Өсвөр нас бол ажиллах хөдөлмөрлөх, хөдөлмөрт дурлах, идэвхжих нас юм . Гэр бүл, сургууль дээр зөв зохион байгуулагдсан хөдөлмөр бол зөвхөн хөдөлмөрт хандах хүний сайн талын харьцааг төлөвшүүлээд зогсдоггүй, харин бие хүний бүх шинжүүдийг төлөвшүүлнэ. Тэрчлэн хөдөлмөрийн процесс

бэрхшээлийг давах чадвар, хүч энерги, идэвхи санаачлага, тэсвэр хатуужил, зориг эрмэлзэл, мөн хамт олонч чанар хувийн сонирхлыг хамт олны сонирхолд захируулах чадвар зэрэг зоригийн шинжүүд төлөвшин тогтоно. Өсвөр насны хүүхдийн хийх хөдөлмөр бол санаачлагыг ундруулсан бүтээлч хөдөлмөр байх ёстой.

- с. Өсвөр үеийнхний онцлог. Өсвөр насны хүүхдийн өөр нэг онцлог нь энэ үедээ маш их оргилсон эрч хүчтэй, аливаа юманд санаачлагатай ханддаг чанар юм. Зарим тохиолдолд энэ маш их эрч хүчтэй байдал нь зөрчилдөмтгий, түр зан чанаруудаар илрэх нь бий. Энэ бол хүүхдийн мэдрэлийн тогтолцоо маш хөөрөмтгий болдогтой холбоотой. /Б.Мөнгөнцэцэг/


### **Гурав: Судалгааны ач холбогдол**

Сурагчдын дунд судалгаа хийснээрээ тэдний хичээл сургалтандаа хандах хандлагыг тодорхойлох, сургалт, хүмүүжлийн ажлын сэтгэл ханамжийг гаргаж ирэх, өмнө нь сурч байсан сургуулийнх нь давуу талаас туршлага судлаж, өөрийн сургууль дээр нэвтрүүлж болохуйц оюутны сурах идэвхи, эрмэлзлэлийг нэмэгдүүлэх оновчтой санаа, шинэ боломжуудыг судлах.


### **Дөрөв. Судалгааны дүн**

1. Судалгааг түүврийн аргаар авсан ба 25 ангийн 158 суралцагч оролцсон.  
Насны хувьд авч үзвэл



№	Судалгаанд оролцогчдын нас	Тоогоор	Хувь
1	14	4	2,53
2	15	40	25,32
3	16	52	32,91
4	17	21	13,29
5	18	8	5,06
6	19	26	16,46
7	20	7	4,43
Нийт		158	



2. Өглөөний дасгал хийдэг үү гэсэн асуултанд:  
Тийм гэж 25 буюу судалгаанд оролцогчдын 15,8% нь,  
Үгүй гэж 133 буюу 84,2% нь хариулжээ.



3. Та хичээлээсээ хоцорч байсан уу гэсэн асуултанд: Тийм гэж 96 буюу судалгаанд оролцогчдын 60,7% нь, Үгүй гэж 62 буюу 39,2% нь хариулжээ.





4. Хичээлээс гадуур ямар нэг сонгон, секц дугуйланд явдаг уу? гэсэн асуултанд:  
Тийм гэж 53 буюу судалгаанд оролцогчдын 33,5% нь,  
Үгүй гэж 105 буюу 66,5% нь хариулжээ.
5. Та өөрийн сурдаг сургуулиараа бахархдаг уу? гэсэн асуултанд:  
Тийм гэж 105 буюу судалгаанд оролцогчдын 70,2% нь,  
Үгүй гэж 53 буюу 29,8 % нь хариулжээ.
6. Бахархдаг бол яагаад, ямар үндэслэлээр гэдэг асуултанд:
- a. Нэр хүнд сайтай
  - b. Багш нарын харилцаа
  - c. Чадварлаг хамт олон
  - d. Багш нар нь хичээлээ сайн заадаг
  - e. Сургалт сайтай
  - f. Гадаад харилцаа сайтай
  - g. 50 жилийн түүхтэй
  - h. Бүх зүйлд манлайлагч байдаг
  - i. Бүтээлч сургууль
  - j. Төгсөгчид нь мэргэжлээрээ ажилладаг
  - k. Дэг журамтай гоё сургууль
  - l. Шилдэг нэрээ гаргасан сургууль
  - m. Сонгосон мэргэжлээрээ чадвартай болно
  - n. Багш ажилчид нь 10 жилийнхээс өөр
  - o. Техник, технологи сайн
  - p. Олон мундаг хүмүүс энэ сургуулиас гараагаа эхэлдэг
  - q. Гандийд сурч байгаадаа гэж бодохоор сайхан байдаг
7. Сургууль дээрх соёл, хүмүүжлийн ажлуудаас хамгийн их таалагдсан ажил:
- a. Түүхийн сургамж ба ирээдүй лекц
  - b. Олимпиад, уралдаан тэмцээнүүд
  - c. Их цэвэрлэгээ
  - d. Музей үзэх
  - e. Урлагын үзлэг
  - f. Та 5-р ангийн хүүхдээс ухаантай юу
  - g. Энэтхэгийн соёлыг үзэх
8. Төгссөн сургууль дээр чинь зохион байгуулагддаг байсан сонирхолтой ажлыг нэрлэнэ үү?
- a. Хаврын баяр
  - b. Аялал зугаалга
  - c. Спортын өдөрлөг
  - d. Бүх хүүхдийг секц дугуйланд хамруулахыг хичээдэг байсан нь

- e. Хувиарийн дагуу ангиуд зааландаа тоглодог байсан
  - f. Их завсарлагаанаар дасгал хийдэг байсан
  - g. Өглөө бүр төрийн дуулал дуулдаг байсан
  - h. Дүрэмт хувцасаа өмсдөг байсан
9. Таны сурах хүсэл эрмэлзлэлийг нэмэгдүүлэхийн тулд сургуулийн зүгээс ямар үйл ажиллагаа зохион байгуулах хэрэгтэй гэж үзэж байна вэ?
- a. Секц, дугуйлангууд
  - b. Танилцах үдэшлэг
  - c. Нийгмийн талаас дэмжих
  - d. Бусад ангийн хүүхдүүдтэй танилцах
  - e. Сонирхолтой IQ талаас нь хичээлээ заах
  - f. Хүүхдүүдийн харилцаа, хараал аль болох бага хэлүүлэх
  - g. Бүх хүүхдийг хамарсан үйл ажиллагаа
  - h. Мод тарих
  - i. Мэргэжлийн хичээлийн цагийг нэмэх
  - j. Дэг журамтай байх
10. Олуулаа нэгдэн төрийн дуулал дуулах нь ямар сэтгэгдэл төрдөг вэ?
- a. Эх орондоо хэрэгтэй хүн болно гэж бодож омогших сэтгэл төрдөг
  - b. Монгол хүн гэж омогшдог
  - c. Өвөг дээдсээрээ бахархах сэтгэл төрдөг
  - d. Маш гоё өөдрөг сэтгэлтэй болдог
  - e. Улс орноороо бахархдаг
  - f. Сэтгэл өөдрөг, өөртөө итгэлтэй болдог
  - g. Бахархалтай, эрч хүч ордог
  - h. Сэтгэл догдолдог
  - i. Монгол хүн болсондоо бахархдаг
  - j. Бид улс орныхоо ирээдүй, хөгжлийг өөрсдөө бүтээнэ
  - k. Монгол орноо хөгжүүлэх урам зориг авдаг
  - l. Үгээр хэлэхийн аргагүй мэдрэмж
  - m. Аархал төрдөг

### **Тав. Дүгнэлт**

1. Судалгааны дүнгээс харахад суралцагчдын насны хувьд ихэнх нь 16-17 буюу шилжилтийн настай. Энэ нь тэдний нас, сэтгэлзүйн онцлогын хувьд маш эмзэг үе.

2. Өглөөний дасгал хийдэггүй, хичээлээс гадуурх дугуйлан секцэд хамрагдалт хангалтгүй байгаа нь хүүхдийг хөдөлгөөний дутагдалтай, сул дорой, залхуу байдалд хүргэж байна. Дасгал хөдөлгөөн байнга хийж биеийн зөв хөгжилтэй байх нь тархийг бас хөгжүүлдэг. Судалгаагаар дасгал хийсний дараа хүмүүс

шинэ үгсийг 20% хурдан цээжилж байжээ.

Гурван сар тогтмол дасгал хийсний дараа тархины ой тогтоомжийн хэсэгт цусан хангамж нэмэгдсэнээр суралцах чадвар 30% өссөн нь тогтоогдсон гэсэн судалгаа ч байдаг.

3. Сурагчдын дийлэнх олон шалтгааны улмаас хичээлдээ хоцорч байсан гэдэг нь хувь хүний хариуцлагыг нэмэгдүүлэх хэрэгцээ байна.

4. Олонхи сурагчид маань сургуулиараа бахархах сэтгэлтэй, ирээдүйдээ итгэх итгэлтэй байгаа нь сайн хэрэг.

### **Зургаа: Цаашид хэрэгжүүлж болохуйц санаа**

Өнөөдөр сургуулийн хэмжээнд сурагчдыг хөгжүүлэх, төлөвшүүлэх олон ажил хийгдэж байгаа ч магадгүй өөр ажил хэрэгжүүлж, хэвшүүлбэл сурагчдын хандлага, сурах эрмэлзлэл улам бүр сайжрана

**Өглөө бүр хичээл эхлэхээс өмнө сургуулийнхаа нийт суралцагчдын сурах хүсэл эрмэлзлэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлэх.**

**Үүнд:**

- ✓ Сургуулийн нэгдсэн уриатай болох  
Багш, сурагч, ажилчид уриагаа хэлэн, эрч хүчтэйгээр ажлаа эхлүүлэх
- ✓ Төрийн дуулалаа дуулах  
Монгол улсаараа бахархан, омогшиж, хийж бүтээх урам зоригтой болно
- ✓ Дасгал хөдөлгөөн хийх, Flash movie хийх  
Сэтгэл сэргэж, сурах эрмэлзлэл нэмэгдэнэ, ой тогтоолт сайжирна.
- ✓ Оюутны байранд амьдардаг сурагчдыг тогтмол цагт унтуулж, босгож хэвшүүлэх  
Насан туршийн амьдралын зөв дадал хэвшилтэй болно.
- ✓ 2,5 жилтэй ангийн 1-р курсуудыг тогтмол 8 цагт хичээлтэй байхаар зохицуулах  
Тогтмол цагт босч сурна.
- ✓ Намар сургуулиараа явган аялал хийх

**Долоо. Ном зүй:**

1. Сэтгэл зүйд өөрөө суралцах нь. Улаанбаатар 2005 он
2. Өөрөө өөртөө сэтгэл зүйч. Улаанбаатар 2007 он.
3. <http://www.zuvluguun.edu.mn/>